



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/73

Шивээговь сум

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын
улсын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/51 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Сумын нутаг дэвсгэрт тээврийн хэрэгслийн техникийн хяналтын улсын үзлэг, оношилгоог явуулах ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ч.Уранбилэг

(Цагдаагийн хэсгийн зохицуулагч,
цагдаагийн дэслэгч)

Гишүүд:

Н.Амаржаргал

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Ё.Батцэнгэл

(Шивээ-Овоо хувьцаат компанийн Тээвэр
үйлчилгээний хэсгийн механик)

421217439

3. Сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, 1, 2 дугаар багийн иргэдийг хуваарийн дагуу автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг оношилгоонд хамруулж, зохион байгуулж ажиллахыг комиссын дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

4. Өөрийн багийн болон байгууллагын эзэмшил, харьяаллын тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж хуваарийн дагуу тооллогод хамруулахыг 1, 2 дугаар багийн Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ